



## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2018 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А-144

Улаанбаатар хот

### Ёс зүйн дүрэм батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголбанкны ажилтны ёс зүйн дүрэм”-ийг хавсралтаар шинэчлэн баталж, 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. “Монголбанкны ажилтны ёс зүйн дүрэм”-ийг ажилтнуудад танилцуулахыг бүх газар, бие даасан нэгж, орон нутаг дахь хэлтэс, салбарын захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. “Монголбанкны ажилтны ёс зүйн дүрэм”-ийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг нийт ажилтнуудад даалгасугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Ж.Батхуяг), Дотоод аудитын газар (Д.Аюуш)-г тус тус үүрэг болгосугай.

5. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 173, 2014 оны 12 дугаар сарын 31-ний А-223 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН



Н.БАЯРТСАЙХАН

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны  
5 дугаар сарын 13-ны өдрийн А-144 дугаар  
тушаалын хавсралт



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



## МОНГОЛБАНКНЫ АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

**Мөрдөгдөж эхлэх хугацаа:** 2018 оны 06 дугаар сарын 01-ний өдөр  
**Бодлогыг хариуцагч:** Ёс зүйн маргаан хянан шийдвэрлэх Комисс, Тамгын газар  
**Хэрэгжилтийг хянах давтамж:** жил бүр

## ӨМНӨХ ҮГ

Монголбанкны нийт ажилтан, алба хаагчид аа!

Та бид ёс зүйн өндөр ухамсар, зан төлөвийг эрхэмлэн Төв банкны зорилго, зорилт, үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг хэлбэрэлтгүй биелүүлэх үүрэгтэй билээ. Хуулиар тогтоосон энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхэд байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, ерөнхий зарчмыг тогтоож, оновчтой тодорхойлсон байх нь Төв банкны өдөр тутмын үйл ажиллагаанд онцгой ач холбогдолтой гэж үзэж “Монголбанкны ажилтны ёс зүйн дүрэм”-ийг батлан мөрдүүлэхээр тогтоож байна. Та бүхэн “Монголбанкны ажилтны ёс зүйн дүрэм”-ийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж, ёс зүйн аливаа зөрчлөөс ангид байж, эрхэлсэн ажил, хариуцсан чиг үүргээ гагцхүү хуулийн хүрээнд зохих ёсоор хэрэгжүүлнэ гэдэгт Монголбанкны Ерөнхийлөгчийн хувьд итгэлтэй байна.

Монголбанкны үйл ажиллагаа гагцхүү Монгол Улсын нийгмийн хөгжил дэвшил, эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэгдэж, иргэн, айл өрх бүрийн амьдралд эерэг нөлөө үзүүлж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжсэн, улс орны санхүүгийн тэргүүлэх хүч нь байх болтугай!

Хүндэтгэсэн

Н.Баяртсайхан  
Монголбанкны Ерөнхийлөгч

## МОНГОЛБАНКНЫ АЖИЛТНЫ ТАНГАРАГ

“Монголбанкны ажилтан Би Монгол Улсын хууль тогтоомжийг сахин биелүүлж, Монголбанкны нэр төрийг чандлан хамгаалж, улс орны нийтлэг эрх ашиг, хөгжлийн төлөө өөрийн оюун ухаан, эрдэм мэдлэг, ур чадвараа зориулж чин шударгаар зүтгэхээ батлан тангараглая.”

## **1. ЗОРИЛГО**

Ёс зүйн дүрэм нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулиар тодорхойлсон зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд Монголбанкны ажилтны заавал баримтлах ёс зүйн хэм хэмжээ, ерөнхий зарчмыг тодорхойлоход оршино.

## **2. ЕРӨНХИЙ ЗАРЧИМ**

Монголбанкны ажилтан нь Монгол Улсын нийтлэг эрх ашгийг эрхэмлэж, шударга бус аливаа зүйлтэй үл эвлэрч, бусадтай хүндэтгэлтэй харьцаж, бусдад эрх тэгш хандан, эрхэлсэн ажил үүргээ зохих ёсоор хариуцлагатай, хараат бусаар хэрэгжүүлж, өндөр ёс зүйтэй байна.

### **Монгол Улсын нийтлэг эрх ашгийг эрхэмлэх**

Монголбанкны ажилтан нь хуулиар тогтоосон Төв банкны зорилго, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ гагцхүү Монгол Улсын нийтлэг эрх ашгийг эрхэмлэж, нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас ямагт дээгүүр тавьж ажиллана.

### **Шударга бус аливаа зүйлтэй үл эвлэрэх**

Монголбанкны ажилтан нь шударга бус аливаа зүйлтэй үл эвлэрэн, хариуцсан ажил үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлнэ. Ажилтан Монголбанкны нэр төр, албаны нэр хүндийг ямагт өндөрт өргөж, хууль бус, шударга бус үйлдлээс ангид байна.

### **Бусадтай хүндэтгэлтэй харьцаж, бусдад эрх тэгш хандах**

Монголбанкны ажилтан уламжлалт ёс, зан заншлаа дээдлэн, бусадтай хүндэтгэлтэй, найрсаг, нөхөрсөг, хамтач, шударга, ажил хэрэгч байдлаар харьцаж, аливаа асуудал дээр бусдад эрх тэгш хандана. Бусдыг бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны албадлага, эрхшээл, дарамтад оруулах, эдийн болон эдийн бус хохирол учруулах аливаа үйлдлийг ил, далд аливаа хэлбэрээр үл гаргана.

### **Эрхэлсэн ажил үүргээ зохих ёсоор, хариуцлагатай, хараат бусаар хэрэгжүүлэх**

Монголбанкны ажилтан нь өөрийн хариуцсан ажил, чиг үүргийг зохих ёсоор хэрэгжүүлж, үр дүнг шууд хариуцан ажиллаж, бусдын дарамт, нөлөөлөлд автахгүйгээр, ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ажиллана. Ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх аливаа хүчин зүйлсээс ямагт зайлсхийнэ.

### **Ажил хэрэгч байдлыг эрхэмлэх**

Хов жив, хэрүүл хийх, бүдүүлэг авир гаргах, нэр төр, албан тушаал хөөцөлдөх, ажил үүргийн биелэлт, гүйцэтгэлээс бусад байдлаар удирдах албан тушаалтнаас давуу байдлыг олж авахыг цээрлэнэ. Аливаа асуудалд хов жив, цуу ярианд бус, албан ёсны үнэн зөв, бодит мэдээ, дүгнэлтэнд үндэслэж хандана.

Ажилтан ажлын байрны тодорхойлолтод зааснаас бусад тухайн ажилтны чиг үүрэгт хамааралгүй, хувийн ажил, үйлдэл гүйцэтгүүлэхээр санал болгох, шаардах, өөрийн чиг үүрэгт хамаарахаас бусад тохиолдолд аливаа асуудлыг өөрт тайлагнах, мэдээлэх, хянуулахаар шаардахыг хориглоно.

Удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй үр дагавар, эрсдэл, сөрөг талыг урьдчилан анхааруулж ажиллана. Удирдах,

удирдуулах ёсны зарчмыг баримталж, тодорхой асуудлаар өөр саналтай байсан ч удирдах ажилтны хуульд нийцсэн шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь хичээнгүйлэн гүйцэтгэнэ.

### **Хариуцлагатай байх**

Монголбанкны ажилтан нь өөрт оногдсон ажлын байрны шаардлагыг бүрэн хангаж, үндсэн ажил үүрэг, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэнэ. Хариуцсан ажлыг чанарын шаардлага хангасан түвшинд хийж гүйцэтгэхийн төлөө өөрийгөө бүх талаар дайчлан ажиллаж, ажлын хариуцлагыг бүрэн хүлээн, ажил мэргэжилдээ ямагт хүндэтгэлтэй хандана. Ажиллаж байгаа орчноо хог хаягдалгүй цэвэр цэмцгэр байлгаж, байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгслийг хайрлан хамгаалж, үр ашигтай ашиглана.

### **3. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ**

Монголбанкны ажилтан нь албан ажил гүйцэтгэхэд олгогдсон бүрэн эрхээ хувийн болон аливаа иргэн, хуулийн этгээдийн зорилго, үйл ажиллагаанд ашиглахаас сэргийлэх бөгөөд албан үүргээ гүйцэтгэхэд нөлөөлөхүйц аливаа ашиг сонирхлын зөрчилтэй харилцаа, үйл ажиллагаанаас ангид байна. Албан үүргээ гүйцэтгэхдээ улс үндэстний (нийтийн) эрх ашгийг ямагт хувийн болон бусад ашиг сонирхлоос илүүд үзэж Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, бусад хуулийг баримтална.

Аливаа ашиг сонирхлын зөрчил үүсч болох тохиолдолд ажилтан энэ талаар удирдлагад мэдэгдэж, зөвлөмжийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийж ажиллана.

Ашиг сонирхлын зөрчлүүд дараах хэлбэрээр үүсч болзошгүй бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй өөр нөхцөл үүссэн тохиолдолд ёс зүйн маргаан хянан шийдвэрлэх Комисс / цаашид “Комисс” гэх/ -оор хэлэлцүүлж, зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

*Бэлэг, үнэ бүхий зүйлс авах.* Монголбанкны ажилтан нь албан ажил үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан аливаа этгээдээс бэлэг түүнтэй адилтгах зүйлс (мөнгөн хөрөнгө, бэлэг дурсгал, шагнал урамшуулал гэх мэт) авахаас татгалзана. Ажилтанд ажил үүрэгтэй нь холбогдолгүй өгсөн бэлэг үүнд хамаарахгүй. Ажилтанд албан үүрэгтэй нь холбогдуулан өгсөн бэлэг түүнтэй адилтгах зүйлсийн үнийн дүн тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд уг албан тушаалтан энэ тухай Комисст “Бэлэг, түүнтэй адилтгах эд зүйлсийг мэдүүлэх маягт”-ын дагуу 30 хоногийн дотор мэдэгдэнэ. Эдгээр бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны зургаан сарын цалингийн хэмжээнээс бага бол тухайн ажилтан өөрт үлдээж болно. Харин тус дүнгээс өндөр тохиолдолд Монголбанкинд хандивлана. Ажилтан зургаан сарын цалингийн хэмжээнээс илүү гарсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсний зөрүүг өөрөө төлж тухайн бэлэг, үйлчилгээг хүлээн авч болно.

*Олон нийтийн арга хэмжээнд оролцох, төлөөлөх.* Монголбанкны нэр хүндэд харшлахаар аливаа арга хэмжээнд оролцохоос татгалзана. Монголбанкны ажилтан албан үүрэгт нь хамаарахаас бусад тохиолдолд аливаа зар сурталчилгаа, үүнтэй адилтгах арга хэмжээнд Монголбанкны албан нэр, албан тушаалын байдлаа ашиглан оролцож үл болно. Өөрийн албан үүрэгт хамаарахаас бусад арга хэмжээнд зөвхөн удирдлагаас зөвшөөрсний дагуу Монголбанкны байр суурийг илэрхийлж оролцоно. Бусад тохиолдолд өөрийн санаа бодол, байр суурь нь Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болохыг заавал тодорхой мэдэгдэнэ. Аливаа арга хэмжээнд Монголбанкийг төлөөлөн оролцохдоо түүний нэр хүндийг өндөрт өргөсөн зөв үйл хөдлөлийг эрхэмлэнэ.

## БЭЛЭГ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЭД ЗҮЙЛСИЙГ МЭДҮҮЛЭХ МАЯГТ

Овог, нэр:

Газар (хэлтэс, алба), салбарын нэр:

№	Бэлэг, түүнтэй адилтгах зүйлсийн нэр	Хүлээн авсан Он/сар/өдөр	Хэнээс/ ямар байгууллагаас өгсөн	Бэлэг, түүнтэй адилтгах зүйлсийн төрөл	Үнийн дүн /мянган төгрөгөөр/

Маягт бөглөсөн ажилтан: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Ёс зүйн маргаан хянан шийдвэрлэх  
комиссын дарга: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

..... он ..... сар ..... өдөр